



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ 2020 ОНЫ ЭХНИЙ 9 САР



Улаанбаатар хот 2020 он

Сонгинохайрхан дүүрэг нь 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 93521 өрхийн 327580 хүн амтай болжээ. 2020 оны гуравдугаар улирлын байдлаар дүүргийн хэмжээнд 1895 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийслэл хотод бүртгэгдсэн хэргийн 15.3 хувь болж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1196(38.7%) хэргээр буурсан байна. 2020 оны гуравдугаар улирлын байдлаар Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргийн түвшин 87.7 промилл, хүүхэд оролцсон хэргийн эзлэх хувь 4.2 байна. Сонгинохайрхан дүүрэгт тайлант оны гуравдугаар улиралд бүртгэгдсэн нийт хэргийн 1377(72.7%) нь хөнгөн, 519(27.3%) нь хүнд хэрэг байна. Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт гарсан хөнгөн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 868(38.7%) хэргээр, хүнд гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 327(38.6%) хэргээр тус тус цөөрсөн байна.

Хүснэгт 1. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, дүүргээр


Дүүрэг	Бүх хэрэг			Гэмт хэргийн ангилал					
				Хөнгөн			Хүнд		
	2019.09	2020.09	өөрчлөлт	2019.09	2020.09	өөрчлөлт	2019.09	2020.09	өөрчлөлт
Нийслэл	17564	12350	70.3	14174	10464	73.8	3390	1886	55.6
Баянгол	2704	1940	71.7	2465	1812	73.5	239	128	53.6
Баянзүрх	4629	3324	71.8	3671	2865	78.0	958	458	47.8
Сүхбаатар	2883	2065	71.6	2367	1781	75.2	516	284	55.0
Сонгинохайрхан	3091	1895	61.3	2245	1377	61.3	846	519	61.3
Хан-уул	1703	1252	73.5	1453	1075	74.0	250	177	70.8
Чингэлтэй	2145	1453	67.7	1648	1192	72.3	497	261	52.5
Багануур	141	115	81.6	114	97	85.1	27	18	66.7
Багахангай	13	18	138.5	13	17	130.8	0	1	0.0
Налайх	255	267	104.7	198	245	123.7	57	42	73.7

Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 228(12.0%) нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 2(0.9%) хэргээр өссөн бол эмэгтэй хүн оролцсон хэрэг 203(10.7%) гарсан нь өнгөрсөн оны өмнөх үеэс 45(18.1%) хэргээр, хүүхэд оролцсон хэрэг 79(4.2%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 29(26.9%) хэргээс тус тус буурсан байна. Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 933(49.2%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 512(27.0%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 451(23.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус харьяалагдаж байна.

Хүснэгт 2. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо

Үзүүлэлт	Он	Бүх хэрэг	Гэмт хэргийн ангилал		Согтуугаар үйлдэгдсэн	Хүүхэд оролцсон	Эмэгтэйчүүд оролцсон	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас
			хөнгөн	хүнд				
Сонгинохайрхан	2019.09	3091	2245	848	226	108	248	97
I хэлтэс		1215	860	355	62	40	70	26
II хэлтэс		952	628	326	74	34	66	25
III хэлтэс		924	759	165	90	34	112	46
Сонгинохайрхан	2020.09	1896	1377	519	228	79	203	99
I хэлтэс		933	652	281	66	32	72	33
II хэлтэс		512	350	162	65	30	66	21
III хэлтэс		451	375	76	97	17	65	45
2020/2019		61.3	61.3	61.2	100.9	73.1	81.9	102.1

Дүрслэл 1. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэрэг үйлдэгдсэн байдлаар, дүүргээр



Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 17(0.9%) нь хүний амьд явах эрхийн эсрэг, 625(33.0%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 51(2.7%) нь хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг, 7(0.4%) нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг, 3(0.2%) нь эдийн засгийн эсрэг, 20(1.1%) нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг, 2(0.1%) нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг, 10(0.5%) нь нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг, 1(0.1%) нь хүүхдийн эсрэг, 1(0.1%) нь авлигын эсрэг, 10(0.5%) нь хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг, 3(0.2%) нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, 71(3.4%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэглэлийн ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус байна.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар

Үзүүлэлт	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2020 2019
Он	2019.09				2020.09				
Хүний амьд явах эрхийн эсрэг	65	33	22	10	41	17	14	10	63.1
Хүнийг алах	14	2	7	5	26	10	9	7	185.7
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	44	27	13	4	12	5	5	2	27.3
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	836	358	251	217	625	306	159	180	74.8
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	14	7	7		24	8	10	6	171.4
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	18	2	6	10	8	5	3		44.4
Хүний бэлгийг эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	66	18	33	15	51	24	20	7	77.3
Хүчиндэх	48	16	22	10	47	23	19	5	97.9
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	14	5	3	6	7	4	0	3	50.0
Заналхийлэх	4	1	1	2	1	1			25.0

Хүснэгт 3-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	<u>2020</u> <u>2019</u>
Он	2019.09				2020.09				
Эрүүл мэндийн эсрэг	4	2		2	0				0.0
Эдийн засгийн	17	8	2	7	3	1	1	1	17.6
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	20	9	8	3	20	13	3	4	100.0
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	7	4	2	1	2	1	1		28.6
Нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг	8	3	1	4	10	3	3	4	125.0
Хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг	12	10		2	10	8		2	83.3
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	1			1	3	1	2		300.0
Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэглэлийн ашиглалтын журмын сэрэг	129	79	23	27	71	35	24	12	55.0
Хүүхдийн эсрэг	4	2	1	1	1	1			25.0
Авлигын	4	1	3		1	1			25.0


Тайлант оны гуравдугаар улиралд Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 1050(55.4%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 854(44.9%) хэргээр буурсан байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 656(62.5%) нь хулгайлах гэмт хэрэг байгаа бөгөөд хулгайлах гэмт хэргийн 633(96.5%) нь хувийн өмчийг хулгайлах хэрэг, 14(2.1%) нь авто тээврийн хэрэглэл хулгайлах, 4(0.6%) нь халаасны хулгайн хэрэг байна.

Хүснэгт 4. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо

Үзүүлэлт	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	<u>2020</u> <u>2019</u>
Он	2019.09				2020.09				
Өмчлөх эрхийн эсрэг	1904	673	603	228	1050	517	285	248	55.1
Хулгайлах	1174	457	405	312	656	345	180	131	55.9
Хувийн өмч хулгайлах	1115	445	397	273	633	329	179	125	56.8
Автотээврийн хэрэгслэл хулгайлах	24	9	4	11	14	10	1	3	58.3
Халаасны хулгай	31	2	2	27	4	3		1	12.9
Дээрэмдэх	120	18	39	69	66	26	14	26	55.0
Залилах	398	106	100	192	236	90	68	78	59.3
Хөрөнгө завших	38	20	10	8	18	8	4	6	47.4
Эд хөрөнгө устгах, гэмтээх	27	7	14	6	19	10	7	2	70.4
Мал хулгайлах	46	46			23	23			50.0

Тайлант хугацаанд дээрэмдэх гэмт хэрэг 66(6.3%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 54(45.0%) хэргээр, залилах гэмт хэрэг 236(22.5%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 162(40.7%) хэргээр, хөрөнгө завших хэрэг 18(1.7%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 20(52.6%) хэргээр, эд хөрөнгө устгах гэмтээх хэрэг 19(0.9%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 8(29.6%) хэргээр, мал хулгайлах гэмт хэрэг 23(2.3%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 23(50.0%) хэргээр тус тус буурсан байна.

Дүрслэл 2. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, дүүргээр



Хүснэгт 5. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр

Үзүүлэлт	Он	Бүх хүн	Эмэгтэй	насны бүлэг										
				15 хүртэлх	16-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60+
Бүгд	2019.09	1322	187	41	85	276	282	213	168	102	68	45	28	14
I хэлтэс		593	70	19	38	107	136	107	65	47	33	24	10	7
II хэлтэс		334	54	10	19	81	59	48	48	31	17	9	8	4
III хэлтэс		395	63	12	28	88	87	58	55	24	18	12	10	3
Бүгд	2020.09	1134	163	44	51	223	243	181	134	104	70	47	24	13
I хэлтэс		550	60	18	23	104	114	79	67	58	37	28	15	7
II хэлтэс		287	53	15	17	67	52	55	28	20	18	9	4	2
III хэлтэс		297	50	11	11	52	77	47	39	28	15	10	5	4
2020/2019		85.8	87.2	107.3	60.0	80.8	86.2	85.0	79.8	102.0	102.9	104.4	85.7	92.9

Сонгинохайрхан дүүрэгт тайлант оны гуравдугаар улирлын байдлаар гэмт хэрэг үйлдсэн 1134 хүн байгаа нь өмнөх оны мөн үеийн гэмт хэрэг үйлдсэн хүнээс 188(14.2%) хүнээр буурсан байна. Нийт гэмт хэрэг үйлдсэн хүний 163(14.4%) нь эмэгтэй, 44(3.9%) нь 15 хүртэлх насны хүүхэд, 13(1.1%) нь 60 түүнээс дээш насны хүн байна. Тайлант хугацаанд гэмт хэрэг үйлдсэн иргэдийн 51(4.5%) нь 16-17 настай, 223(19.7%) нь 18-24 настай, 243(21.4%) нь 25-29 настай, 181(15.9%) нь 30-34 настай, 134(11.8%) нь 35-39 настай, 104(9.2%) нь 40-44 настай, 70(6.2%) нь 45-49 настай, 71(6.3%) нь 50-59 настай байна.

Тайлант хугацаанд гэмт хэрэг үйлдсэн иргэдийн 22(1.9%) нь төрийн албан хаагч, 80(7.1%) хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 11(0.9%) нь төрийн бус байгууллагын ажилтан, 290(25.6%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 25(2.2%) нь малчин, 14(1.2%) нь оюутан, 30(2.6%) нь сурагч, 23(2.0%) нь сургууль завсардсан, тэнэмэл хүүхэд, 4(0.4%) нь хоригдол, 635(56.0%) нь ажилгүй иргэн байна. Өнгөрсөн оны мөн үед гэмт хэрэг үйлдсэн ажилгүй иргэн 822 байсан бол тайлант хугацаанд 187(22.7%) хүнээр цөөрсөн байна.

Хүснэгт 6. Гэмт хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар

Үзүүлэлт	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	Бүгд	I хэлтэс	II хэлтэс	III хэлтэс	2020 2019
Он	2019.09				2020.09				
Төрийн албан хаагч	15	6	3	6	22	16	1	5	146.7
Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	88	24	8	56	80	22	7	51	90.9
Төрийн бус байгууллагын ажилтан	13	6	1	6	11	5	2	4	0.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	262	115	75	72	290	168	65	57	110.7
Малчин	16	13	1	2	25	22		3	0.0
Оюутан	35	9	4	22	14	4	3	7	40.0
Сурагч	50	22	9	19	30	15	9	6	60.0
Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	14	2	3	9	23	7	7	9	164.3
Хоригдол	7	4	3		4		4		57.1
Ажилгүй	822	392	227	203	635	291	189	155	77.3

Тайлант хугацаанд гэмт хэрэг үйлдэгсэдийн 26(2.3%) нь боловсролгүй, 108(9.5%) нь бага боловсролтой, 266(23.5%) нь суурь боловсролтой, 567(50.0%) нь бүрэн дунд боловсролтой, 28(2.5%) нь тусгай мэргэжилийн дунд боловсролтой, 139(12.3%) нь дээд боловсролтой байна.

Хүснэгт 7. Гэмт хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшингээр

Үзүүлэлт	Он	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай мэргэжилийн дунд	Дээд
Сонгинохайрхан	2019.09	31	106	310	702	47	126
I хэлтэс		13	50	136	307	18	69
II хэлтэс		2	19	87	202	7	17
III хэлтэс		16	37	87	193	22	40
Сонгинохайрхан	2020.09	26	108	266	567	28	139
I хэлтэс		6	52	154	275	11	52
II хэлтэс		11	21	63	163	4	25
III хэлтэс		9	35	49	129	13	62
2020/2019		83.9	101.9	85.8	80.8	59.6	110.3

Оны эхний 9 сард гарсан гэмт хэргийн 302(15.9%) нь даваа гарагт, 270(14.2%) нь мягмар гарагт, 278(14.7%) нь лхагва гарагт, 283(14.9%) нь пүрэв гарагт, 300(15.8%) нь баасан гарагт, 232(12.2%) бямба гарагт, 231(12.2%) ням гарагт тус тус гарчээ. Тайлант хугацаанд гарсан гэмт хэргүүдээс даваа, баасан гарагт бусад өдрүүдээс арай илүү гэмт хэрэг гарсан байна.

Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гарагаар

Үзүүлэлт	Он	Гараг						
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Сонгинохайрхан	2019.09	469	463	465	454	474	384	382
I хэлтэс		201	188	199	186	168	150	125
II хэлтэс		128	130	148	137	156	128	125
III хэлтэс		140	145	118	131	152	106	132
Сонгинохайрхан	2020.09	302	270	278	283	300	232	231
I хэлтэс		151	135	145	138	155	97	112
II хэлтэс		83	61	68	87	77	79	57
III хэлтэс		68	74	65	58	68	56	62
2020/2019		64.4	58.3	59.8	62.3	63.3	60.4	60.5


Оны эхний 9 сард гарсан нийт гэмт хэргийн 488(25.8%) нь 06-14 цагт, 612(32.3%) нь 14-19 цагт, 305(16.9%) нь 19-22 цагт, 491(25.9%) нь 22-06 цагт тус тус гарчээ. Гэмт хэрэг гарсан цагаас 14-19 цаг буюу өдрийн цагт гарсан гэмт хэрэг бусад цагуудаас их байна.

Хүснэгт 9. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, цагаар

Үзүүлэлт	Он	Цаг			
		06-14	14-19	19-22	22-06
Сонгинохайрхан	2019.09	845	892	520	834
I хэлтэс		319	321	205	370
II хэлтэс		277	283	191	201
III хэлтэс		249	288	124	253
Сонгинохайрхан	2020.09	488	612	305	491
I хэлтэс		250	284	138	261
II хэлтэс		133	193	78	108
III хэлтэс		105	135	89	122
2020/2019		57.8	68.6	58.7	58.9

Оны эхний 9 сард гарсан нийт гэмт хэргийн 879(46.4%) нь гэр орон сууцанд гарсан хэрэг бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 461(34.4%) хэргээр буурсан байна. Тайлант хугацаанд гэр орон сууцанд гарсан хэргийн 398(45.3%) нь гэрт, 133(15.1%) нь орон сууцны байранд, 247(28.1%) нь хувийн байшинд, 20(2.3%) нь зуслангийн байшинд, 29(3.3%) нь нийтийн байранд, 17(1.9%) нь орцонд тус тус гарсан байна.

Дүрслэл 3. Гэмт хэргийн тоо, байршилаар, дүүргээр



Хүснэгт 10. Гэр орон сууцанд гарсан гэмт хэргийн тоо,сууцны төрлөөр

Үзүүлэлт	Он	Гэр, орон сууц	гэр	орон сууцны байр	хувийн байшин	зуслангий н байшин	нийтийн байр	орц
Сонгинохайрхан	2019.09	1340	614	183	353	51	38	25
I хэлтэс		560	254	64	147	38	11	7
II хэлтэс		493	262	36	155	13	6	
III хэлтэс		287	98	83	51		21	18
Сонгинохайрхан	2020.09	879	398	133	247	20	29	17
I хэлтэс		422	192	50	129	12	7	5
II хэлтэс		279	154	21	84	8	8	
III хэлтэс		178	52	62	34		14	12
2020/2019		65.6	64.8	72.7	70.0	39.2	76.3	68.0

Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн 336(17.7%) нь гудамж талбайд гарсан гэмт хэрэг байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 373(52.6%) хэргээр цөөрсөн байна. Нийт гудамж талбайд гарсан хэргийн 119(35.4%) нь гэр хорооллын гудамжинд, 85(25.3%) нь орон сууцны хорооллын гудамжинд, 35(10.4%) нь ил зогсоол дээр, 36(10.7%) нь автобусны буудал дээр тус тус гарсан байна.

Хүснэгт 11. Гудамж, талбайд гарсан гэмт хэргийн тоо, төрлөөр

Үзүүлэлт	Он	Гудамж, талбай	гэр хорооллын гудамж	орон сууцны хорооллын гудамж	ил зогсоол	автобусны буудал
Сонгинохайрхан	2019.09	709	222	198	67	86
I хэлтэс		185	57	17	14	10
II хэлтэс		230	124	20	12	28
III хэлтэс		294	41	141	41	50
Сонгинохайрхан	2020.09	336	119	85	35	36
I хэлтэс		82	28	17	10	10
II хэлтэс		113	59	2	8	11
III хэлтэс		141	32	66	17	15
2020/2019		47.4	53.6	42.9	52.2	41.9

Оны эхний 9 сард гарсан гэмт хэргийн 121(6.4%) нь олон нийтийн газар гарсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 202(62.5%) хэргээр буурсан байна. Олон нийтийн газарт гарсан хэргийн 13(10.7%) нь дэлгүүрт, 14(11.6%) нь зочид буудалд, 14(11.6%) нь бааранд, 9(7.3%) нь ресторан, зоогийн газарт, 9(7.3%) нь автовокзалд, 5(4.1%) нь цайны газарт тус тус гарчээ. Өнгөрсөн оны мөн үед дэлгүүрт 58 хэрэг, бааранд 63 хэрэг, зочид буудалд 43 хэрэг гарч байсан бол оны эхний 9 сард дэлгүүр, баар, зочид буудалд гарсан хэргүүд 3.0-4.4 дахин буурсан байна. Цаг үеийн онцгой нөхцөлтэй холбогдуулан зочид буудал, баар ресторанд гарсан хэргийн тоо эрс буурсан байна.

Хүснэгт 12. Олон нийтийн газарт гарсан гэмт хэргийн тоо, хэрэг гарсан байршилаар

Үзүүлэлт	Он	Олон нийтийн газар	дэлгүүр	зочид буудал	баар	ресторан, зоогийн газар	авто вокзал	цайны газар
Сонгинохайрхан	2019.09	323	58	43	63	19	21	20
I хэлтэс		75	12	10	10	2		5
II хэлтэс		53	10	3	10	1	1	2
III хэлтэс		195	34	30	43	16	20	13
Сонгинохайрхан	2020.09	121	13	14	14	9	9	5
I хэлтэс		42	2	5	3	2	1	2
II хэлтэс		27	8	3	1			1
III хэлтэс		52	5	6	10	7	8	2
2020/2019		37.5	22.4	32.6	22.2	47.4	42.9	25.0


Тайлант оны гуравдугаар улиралд нийтийн тээвэрт 18(0.9%) хэрэг гарсан нь өмнөх оны мөн үеэс 14(43.8%) хэргээр цөөрсөн байна. Нийтийн тээвэрт гарсан нийт хэргийн 5(35.7%) нь том оврын автобусанд, 2(11.1%) нь дунд оврын автобусанд, 7(38.9%) нь таксинд тус тус гарсан байна. Тайлант хугацаанд микро автобусанд хэрэг гараагүй байна.

Хүснэгт 13. Нийтийн тээвэрт гарсан гэмт хэргийн тоо, төрлөөр

Үзүүлэлт	Он	нийтийн тээвэр	том оврын автобус	дунд оврын автобус	микро	такси
Сонгинохайрхан	2019.09	32	9	4	0	14
I хэлтэс		15	1	3		7
II хэлтэс		6	3	1		1
III хэлтэс		11	5			6
Сонгинохайрхан	2020.09	18	5	2	0	7
I хэлтэс		4		1		1
II хэлтэс						
III хэлтэс		14	5	1		6
2020/2019		56.3	55.6	50.0	0.0	50.0

Тайлант хугацаанд гарсан нийт хэргийн 6(0.3%) нь төрийн байгууллагад, 9(0.5%) нь төрийн бус байгууллагад, 124(6.5%) нь аж ахуйн нэгжид, 71(2.9%) нь авто зам дээр тус тус гарсан байна. Өнгөрсөн оны мөн үед төрийн байгууллагад 30 хэрэг гарсан байсан бөгөөд тайлант хугацаанд гарсан хэрэг 14(80.0%) хэргээр буурсан байна. Аж ахуйн нэгжид өнгөрсөн оны мөн үед 244 хэрэг гарсан бол тайлант хугацаанд 124 хэрэг болж 120(49.2%) хэргээр буурсан байна. Тайлант онд авто зам дээр гарсан хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 59(45.4%) хэргээр буурсан байна.

Дүрслэл 4. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, дүүргээр



Хүснэгт 14. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар, төрлөөр

Үзүүлэлт	Он	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж	Авто зам	Бусад
Сонгинохайрхан	2019.1	30	17	244	130	266
I хэлтэс		20	7	95	80	178
II хэлтэс		4	4	58	23	81
III хэлтэс		6	6	91	27	7
Сонгинохайрхан	2020.1	6	9	124	71	332
I хэлтэс		4	5	51	36	287
II хэлтэс		1	4	26	23	39
III хэлтэс		1		47	12	6
2020/2019		20.0	52.9	50.8	54.6	124.8

Тайлант оны гуравдугаар улиралд гарсан гэмт хэргийн улмаас 1879 иргэн хохирсон нь өнгөрсөн оны мөн үеэс 1179(38.6%) иргэнээр буурсан байна. Оны эхний 9 сард гарсан гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 993(52.8%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 433(23.0%) нь хоёрдугаар

хэлтэст, 453(24.1%) нь гуравдугаар хэлтэст тус тус ноогдож байна.Тайлант хугацаанд хохирсон нийт иргэдийн 856 (45.6%) эмэгтэй, 44 (2.3%) нь 13 хүртэлх насны хүүхэд, 58(3.1%) нь 14-17 насны, 221(11.8%) нь 18-24 насны, 252 (13.4%) нь 25-29 насны, 369(19.6%) нь 30-34 насны, 263 (14.0%) нь 35-39 насны, 201(10.7%) нь 40-44 насны, 170(9.0%) нь 45-49 насны, 121(6.4%) нь 50-54 насны, 82(4.4%) нь 55-59 насны, 98 (5.2%) нь 60 ба түүнээс дээш насны иргэд байна.

Хүснэгт 15. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо, насны бүлгээр

Үзүүлэлт	Он	Нийт хохирсон иргэн	эмэгтэй	13 хүртэл настай	14- 17	18- 24	25- 29	30- 34	35- 39	40- 44	45- 49	50- 54	55- 59	60+
Бүгд	2019.09	3058	1419	73	87	339	479	544	413	356	249	206	161	153
I хэлтэс		1354	585	33	32	152	215	246	190	157	105	84	75	44
II хэлтэс		795	391	21	29	77	97	145	113	88	72	59	50	44
III хэлтэс		909	443	17	26	110	167	153	110	111	72	63	36	72
Бүгд	2020.09	1879	856	44	58	221	252	369	263	201	170	121	82	98
I хэлтэс		993	424	29	33	100	113	187	161	108	90	68	51	53
II хэлтэс		433	223	10	11	60	62	77	47	50	43	30	19	24
III хэлтэс		453	209	5	14	61	77	105	55	43	37	23	12	21
2020/2019		61.4	60.3	60.3	66.7	65.2	52.6	67.8	63.7	56.5	68.3	58.7	50.9	64.1

Тайлант оны гуравдугаар улиралд гэмт хэргийн улмаас 8566.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 830.8(10.7%) сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн улмаас гарсан хохиролын 5625.7(65.7%) сая төгрөг нь хөнгөн гэмт хэргийн улмаас 2940.7(34.3%) сая төгрөгийн хохирол хүнд гэмт хэргийн улмаас учирсан байна.

Хүснэгт 16. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Он	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол/ сая төгрөг/		
			хөнгөн	хүнд
Сонгинохайрхан	2019.09	7735.6	5605	2130.6
I хэлтэс		4613	2930.1	1682.9
II хэлтэс		1543.3	1292.7	250.8
III хэлтэс		1579.3	1382.3	197
Сонгинохайрхан	2020.09	8566.4	5625.7	2940.7
I хэлтэс		4161.6	2351.5	1810.1
II хэлтэс		2562.7	2240.4	322.3
III хэлтэс		1842.1	1033.9	808.2
2020/2019		110.7	100.4	138.0

Тайлант оны гуравдугаар улирлын байдлаар нийт 15236 зөрчил гарсан нь өмнөх оны мөн үеэс 2714(21.7%) зөрчлөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 17. Зөрчлийн тоо

Үзүүлэлт	Он	Нийт зөрчил		
			ердийн журмаар шийдвэрлэсэн	хялбаршуулсан журмаар шалгасан
Сонгинохайрхан	2020.09	15236	9801	5435
I хэлтэс		6380	4199	2181
II хэлтэс		3864	2216	1648
III хэлтэс		4992	3386	1606

Сонгинохайрхан дүүргийн статистикийн хэлтэст эмхэтгэн бэлтгэв.